



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

□ 2022 оны хөрөнгө оруулалтын ажлын □
танилцуулга хэвлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүрэгт 2022 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор хөрөнгө оруулалтын ажлын танилцуулгыг хэвлүүлсүгэй.

2. Зарцуулагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3. Танилцуулга хэвлүүлэхэд зарцуулагдах 6,150,000 (Зургаан сая нэг зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 4 сарын 26 ны өдрийн 129 дугаар
захирамжийн хавсралт



2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА
ХЭВЛҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	1 бүрийн үнэ	Нийт үнэ
1	2022 оны хөрөнгө оруулалтын ажлын танилцуулга	Ширхэг	500	12,300	6,150,000
Дүн:					6,150,000